

IV. ДИПЛОМАТЧДЫН ДУРСАМЖ

ТҮҮХТ ХҮМҮҮСИЙН НҮГЭЛ БУЯНЫГ ТҮҮХ Л ДЭНСЭЛНЭ

*МУИС, ОУХС-ийн профессор,
доктор (D.Sc) Ц.Гүрбадам*

Буурал түүхийн хүрд буцалтгүй эргэсээр хүн төрөлхтөн XX зуунаа үдэж XXI зуунтай золголоо. Нэг зуун нөгөөгөөр, өнгөрсөн 2000 жил шинэ мянганаар солигдож буй түүхэн дурсгалт энэ үед дэлхийн улс үндэстэн бүр, түүний дотор бидний монголчууд өнгөрсөн хугацаанд туулсан замаа, хийж бүтээснээ эргэн харж эрэгцүүлэн дүгнэж, оносон алдсанаа оношлон, ирээдүйн зорилгоо тоймлон тодорхойлж байна.

Тэнгэр Бурханаас заяасан Чингис хаан хоёрдахь мянганы түүхт хүн болж дэлхийн хэмжээнд алдаршсан бол манай ард түмэн Ю. Цэдэнбалыг XX зууны Монголын төрийн зүтгэлтэн, гарамгай улс төрчөөр тодруулсан билээ. Монгол улсын нийгэм, улс төр, засгийн удирдлагын залуурыг бараг хагас зууны турш чадмаг залж явсан энэхүү түүхт хүний удирдлаган дор миний бие 18 жил ажиллаж байснаа туйлын аз жаргалтай тохиолдол хэмээн үзэж үргэлж санан дурсаж, баярлаж явдгаа нуух юун. Миний бие 1966-1981 онд Төв Хороонд аж үйлдвэрийн хэлтсийн эрхлэгчээр, 1981-1984 онд "Энх тайван, социализмын асуудал" сэтгүүлийн редакцид МАХН-ын төлөөлөгчөөр, 1984-1990 онд ЗХУ-д элчин сайдаар ажиллах үедээ Цэдэнбал гуайн асар их ажилсаг чанар, өргөн цар хүрээтэй мэдлэг, өндөр боловсрол, ажлын баялаг туршлага, сэтгэлийн их тэнхээ, тэсвэр хатуужлыг харж мэдэрч, бахархан биширч явсны зэрэгцээ амьдралын нь сүүлийн гунигт жилүүдэд Москвад хамт байсан тул түүнийг зүрхнийхээ угаас хайрлан өрөвдөж байсан билээ.

Аж үйлдвэрийн яамны орлогч сайд байсан намайг НТХ-ны хэлтсийн эрхлэгчээр 1966 онд томилогдсоны дараа, өөрөөр хэлбэл "төрийн хар хүн" байснаа "улаан намын ажилтан" болж хувирах ёстой тэрхүү шилжилтийн эхний үед би улс төрийн мэдлэг, асуудлыг судлаж боловсруулах чадвар, намын аргаар удирдах өвөрмөц зарчим зэрэг олон зүйл дээр туршлагагүйдэж байсан. Гэвч ажил нь сонирхолтой байсан тул хурдан дасаж сурахыг чармайн юуны өмнө Ю. Цэдэнбал даргын ажлын арга барилыг анхааралтай ажиж, орос, монголоор бичиж боловсруулсан зүйлийг маань яаж нягтлан засаж найруулсныг нь үг, өгүүлбэр бүрээр задлан шинжилж, түүнээс сургамж авч, цаашдынхаа ажилд үргэлж санаж мөрдөж явдаг байлаа. Түүний удирдлаган дор ажиллаж эхэлсэн үед төрсөн анхны том сэтгэгдэл бол, тэрээр хурц ухаантай, удирдах ажлын арвин их туршлагатай, ном зохиол маш их уншдаг, өөрөөр хэлбэл, аав, ээжийнхээ заяасан төрөлхийн оюун ухааныг ажил, амьдралын ухаанаар

баяжуулж, улмаар эрдэм, номын ухаанаар төгөлдөржүүлсэн удирдагч мөн болохыг олж мэдсэн явдал юм.

“... Хайрт эх орныхоо төлөө өөрийн эцсийн дусал цусыг хүртэл үнэнчээр хүчин зүтгэж, цуцалтгүй ажиллана” хэмээн тангараглаж байсныхаа дагуу Ю. Цэдэнбал дарга өдөр бүр маш олон цагаар шөнө дөл болтол ажиллахын зэрэгцээ номын ухааныг дээдэлдэг донтой тул хэвлэл, зохиол тасралтгүй уншдаг байсан зэргээсээ хувийн амьдрал, эрүүл мэндээ огоорсон төдийгүй, тун бага унтдаг, түүгээрээ бахархдаг, бас коммунизмын үед хүн унтахгүй явж болох эм буй болгох тухай ярьдаг байсан билээ. Ийм удирдагч Монголын түүхэнд төдийгүй дэлхийд ховорхон байсан байх шүү.

Ю. Цэдэнбал гуай социалист орнуудын удирдагчдаас насаараа ахмад нь биш ч гэсэн засгийн эрх барьсан нам, төрийн удирдагчийн хувьд хамгийн ахмад нь, нэг ёсны “дуайен” нь болсон бөгөөд улс төрийн зүтгэлтний баялаг туршлагаас гадна томоохон эдийн засагч, эдийн засгийн шинжлэх ухааны доктор байлаа.

1968 оны 12 дугаар сард НТХ-ны V Бүгд Хурлаар “Үйлдвэрийн газрын хүчин чадлын ашиглалтыг сайжруулах, шинэ үйлдвэрийг мэргэжилтэй ажилчдаар хангах арга хэмжээний тухай” Д. Моломжамц гуайн тавьсан илтгэлийг хэлэлцээд гаргасан тогтоолыг Ю. Цэдэнбал дарга өөрөө орсоор бичсэн бөгөөд түүнийг би уншиж үзээд үнэхээр том эдийн засагч гэдгийг анх ойлгосон юм.

Эдийн засгийн ухаанаас гадна тэрээр орос хэлийг гарамгай сайн эзэмшсэн нь нам, төрийн бодлогыг илэрхийлсэн чухал баримт бичиг боловсруулах, ном, өгүүлэл, илтгэл бичих, зөвлөлтийнхэн болон бусад орны хүмүүстэй ярилцах зэргээс тодорхой харагддаг байсан бөгөөд түүнийг монголоосоо илүү орсоор сайн сэтгэдэг байсан болов уу гэсэн бодол надад нэг бус удаа төрж байсан. МАХН-ын XVI, XVII, XVIII Их Хурлуудад тавих НТХ-ны тайлан илтгэлийн эдийн засгийн хэсгийг нэгтгэн боловсруулж орос хэл дээр бичих, ажлыг түүний даалгавраар гүйцэтгэдэг байсан тул ингэж хэлэх үндэс надад байна. Миний бичсэн зүйлүүдийг түүний засварласан хуудсуудыг би одоо ч нандигнан хадгалсаар явдаг. Илтгэлд нэмж оруулах санаагаа орсоор бичээд өгдөг байсан.

үзэ
аху
төл
их
хэл
үйл
ата
хай
орс
хүч
ээл
Бо
дээ
улс
хол
нүү
ши
зор
түү
ар
хар
бү
мэ
тэм

Товарищу Гурбадаму

Поскольку мой доклад носит отчетный характер, следовало бы привести некоторые общие данные о выполнении пятилетнего плана крупными совместными предприятиями: монголо-советским горно-обогатительным комбинатом "Эрдэнэт", совместной организацией "Монголсовцветмет", Уланбаторской железной дорогой.

Гурбадам
25. 4. 81.

Эдийн засгийн ухааны доктор Ю. Цэдэнбалын улс орноо хөгжүүлэх үзэл баримтлалын нэг ноён нуруу нь Монголоо аж үйлдвэр-хөдөө аж ахуйн орон болгож хувиргах бодлого байсан тул түүнийг хэрэгжүүлэхийн төлөө 1960-аад оноос 1980-аад оны дунд үе хүртэлх 20 гаруй жилийн турш их ч зүтгэсэн, тодорхой үр дүнд ч хүрсэн гэдгийг сайн мэддэгийн хувьд би хэлэх ёстой. Манай улс арвин их нөөцтэй арьс шир, ноос, мах, сүүг үйлдвэрийн аргаар боловсруулж бэлэн бүтээгдэхүүн экспортолдог болсон; атар газар эзэмшиж үр тариа, гурилаар хэрэгцээгээ бүрэн хангасан; зэс ба хайлуур жонш олборлох талаар дэлхийн тэргүүлэгч орнуудын эгнээнд орсон; олон тооны цахилгаан станц барихын зэрэгцээ Төвийн эрчим хүчний систем байгуулж цахилгааны хангамжаар Ази тивд дээгүүр байр эзлэх болсон; Дархан, Эрдэнэт, Сүхбаатар, Чойбалсан, Хөтөл, Багануур, Бор-Өндөр, Бэрх зэрэг үйлдвэрийн шинэ хот, тосгонуудыг "нүцгэн газар дээр" сүндэрлүүлэн босгосон зэрэг амжилт, ололтууд цөм Ю. Цэдэнбалын улс орноо үйлдвэржүүлэх бодлого, түүний гавъяа зүтгэлтэй салшгүй холбоотой. Мянга мянган жил мал маллаж, түүнд шүтэж биширч нүүдэллэсээр ирсэн монголчуудаа оньсон техникээр хийдэг олон төрлийн шинэ ажил, мэргэжилд сургаж, суурин соёл иргэншлийн замд оруулах том зорилтыг хэрэгжүүлэхэд нь их хөрөнгө мөнгө шаардагдсан юм. Гэвч түүнийг шийдвэрлэх талаар Ю. Цэдэнбал дарга улс төр, дипломатын уран арга хэрэглэн, ЗХУ-ын удирдагчидтай тогтоосон хувийн найрсаг харилцаандаа тулгуурлан, улс орныхоо хөгжлийн бэрхшээлүүдийг тал бүрээс нь тайлбарлаж тэдэнд ойлгуулан санхүү, эдийн засаг, техник, мэргэжилтний биетэй тусламж дэмжлэг авч чаддаг байсныг нь цохон тэмдэглэе. Үүний зэрэгцээ бас Зөвлөлт, Хятадын харилцаа туйлдаа хүрч

хурцдаж муудсан тэр жилүүдэд "хятад хөзөр" чадварлаг тоглож чамлахааргүй хөрөнгө мөнгийг ЗХУ-аас салгаж авсан тал ч бий. Иймээс ч Л. И. Брежнев түүнийг "пробивной как лазер" гэж үнэлж байсан удаатай. Энэ нь лазерийн туяа юуг ч нэвтлээд гарч чаддаг шиг ямар ч бэрхшээл, саадыг даваад ажлаа бүтээдэг овсгоотой хүн гэсэн санаа аж.

Монгол Улсын байгалийн асар их баялгийг өргөн цар хүрээтэй олборлон ашиглаж экспортын томоохон эх үүсвэртэй болох, улмаар үйлдвэржүүлэлтийг хурдасгах замаар улс орныхоо хоцрогдлыг багасгах, ард түмнийхээ амьжиргааг сайжруулахад чиглэсэн хэд хэдэн чухал саналыг ЭЗХТЗ-ийн хэмжээнд удаа дараа дэвшүүлэн тавьж байсны гадна Эрдэнэтийн Овооны зэс, молибдений орд газарт ил уурхай, баяжуулах үйлдвэрээс бүрдсэн томоохон комбинат, Эрдэнэт хот байгуулах асуудлыг ЗХУ-д тавихад нь эхний үед Л. Брежнев "битгий их яар" гэж түүнд зөвлөж байсан баримт бий. Гэвч Цэдэнбал гуай харин ч их яарч А. Н. Косыгинд удаа дараа захидал бичиж, биечлэн уулзаж ярилцаар байгаад Монгол-Зөвлөлтийн хамтарсан "Эрдэнэт" үйлдвэр байгуулах саналаа Зөвлөлтийн талаар зөвшөөрүүлээд их гүрний хүчирхэг далайцаар асар богино хугацаанд барьж байгуулуулсан билээ. Эдүгээ "Эрдэнэт" үйлдвэр ядарсан улсын маань аминд орж байгаа нь Ю. Цэдэнбал ирээдүйгээ харж ажилладаг байсны бас нэг тодорхой жишээ баримт юм. Манай улсыг үйлдвэржүүлэх, "Эрдэнэт" мэт эдийн засгийг маань өөд татах томоохон үйлдвэр байгуулахыг дэмждэггүй хүмүүс ЗХУ-ын дээд удирдлага, төрийн яам, газруудад цөөнгүй байсан хийгээд хүнд суртал, хөшүүн механизмын тогтолцооны нөхцөлд асуудлаа энэ мэтээр шийдвэрлүүлж чаддаг байсан явдал түүний улс төр, дипломатын ур чадвараас шалтгаалсан нь ямар ч маргаангүй.

ОХУ-ын эрдэмтэн, монгол судлаач, дипломатч Ш. Г. Надиров "Ю. Цэдэнбал, 1984 он" номдоо: А. Косыгин 1971 онд Монголд айлчлахад нь нэг, хоёрын зэрэг багавтар хүч чадалтай машины үйлдвэр байгуулж өгөх талаар Ю. Цэдэнбалын тавьсан хүсэлтийг тэрбээр зөвшөөрсөн боловч сүүлдээ яам, газрууд нь тийм үйлдвэр алдагдалтай байх болно гэсэн шалтгаар шийдвэрийг нь хүчингүй болгож байсан тухай дурьдаад "... улс төрийн нилээд нөлөө бүхий хүмүүс болон хүч зэвсэг хэрэглэдэг яамныхан Зөвлөлт улсын эдийн засаг, цэргийн хүч чадал, олон улсын нэр хүндийг хадгалан дэмжих зорилтын үүднээс социалист орнууд, түүний дотор Монголыг Москвагаас бүрэн хараат байдалд барьж байх хэрэгтэй гэж үздэг байлаа. Монголын эдийн засаг үндсэндээ түүхий эд нийлүүлэх чиглэлээ хадгалсаар ирсний үндсэн шалтгаануудын нэг үүнд оршиж байсан юм" гэж бичжээ. Энэ нь Кремлийн зарим удирдагчид Ю. Цэдэнбалын улс орноо үйлдвэржүүлэх бодлогод далдуур дургүй байсан талаар миний дээр дурьдсан санааг батлаж байна бус уу.

Зөвлөлтийнхний энэ далд санааг нь Ю. Цэдэнбал гярхай улс төрчийн хувьд гадарлаж байсан тул 1981 онд МАХН-ын XVIII Их Хуралд тавьсан тайлан илтгэлдээ: "Үйлдвэржүүлэх явдал бол аж үйлдвэр бага хөгжсөн орнуудын эдийн засгийн хөгжлийн түвшинг өндөр хөгжилтэй социалист орнуудын түвшинд аажмаар ойртуулан хөгжүүлэх нэн чухал

угтвар нөхцөл мөн” гэж цохон тэмдэглэснээс нь ургуулан бодоход, улс орноо үйлдвэржүүлэх бодлогоос ухрахгүй гэдгээ илэрхийлж байсан болов уу. Нөгөө талаас энэ дүгнэлт нь Ю. Цэдэнбал тэр үеийн онолын үндсэн зарчмуудад тулгуурлан Москвагийн зааврыг тэр бүр хүлээж авахгүй, эвтэйхэн зайлсхийх арга тактик сүвэгчилж чаддаг байсных нь нэг илрэл юм гэж боддог.

Монголоо аж үйлдвэр-хөдөө аж ахуйн орон болгох гэж чармайн зүтгэхийн зэрэгцээ энэ мөчийг бас их харан хүлээж явдгийг нь МАХН-ын XVIII Их Хурлын материал бэлтгэлцэж байхдаа би тодорхой ойлгосон юм. Тэр үеэр манай нэг эрдэмтэн “Монгол улс 15-20 жилийн дараа аж үйлдвэр –хөдөө аж ахуйн орон болж хувирна гэж нөхөр Цэдэнбалын 1966 онд хийсэн дүгнэлт туйлын зөв, алсын хараатай байсан нь эдүгээ батлагдан хэрэгжлээ. Иймд намын Их Хурлаас “БНМАУ-ыг аж үйлдвэр-хөдөө аж ахуйн орон боллоо хэмээн зарлах нь зүйтэй байна” гэсэн утгатай санал бичиж УТТ-ны гишүүдэд тараасан юм. Тэр саналыг УТТ-ны зарим гишүүд дэмжиж байсан бөгөөд Цэдэнбал дарга ч гэсэн дотроо дэмжиж байх шиг санагдсан. Миний хувьд гэвэл, дээрх саналыг оруулах байтугай түүний эсрэг дүгнэлт бичсэн байсан. Тухайлбал, “Манай зорилт нь үйлдвэржүүлэлтийн процессыг цаашид гүнзгийрүүлэхэд оршиж байна... Үйлдвэржүүлэлтийг эрчимжүүлэх явдал машины болон химийн аж үйлдвэрийн зарим төрлийн үйлдвэрлэлийг бий болгож, хөгжүүлэхтэй бас холбоотой юм” гэж бичсэн байлаа. Ийм эрс зөрүүтэй хоёр санал, дүгнэлтийн талаар УТТ-ын гишүүд хэлэлцэж Б. Лхамсүрэн гуай бид хоёрын санал бодлыг сонсоод миний бичсэн зүйлийг Намын Их Хурлын тайлан илтгэлд оруулахаар шийдсэн билээ. Тэр үеийн бодит байдлыг гоёж чимэлгүй, улс төржүүлэлгүй авч үзвэл манай улс анхан шатны үйлдвэржүүлэлтийн асуудлыг л шийдвэрлэж байсан. Ийм нөхцөлд Монгол Улсыг аж үйлдвэр-хөдөө аж ахуйн орон боллоо гэж дүгнэвэл том алдаа болохоос гадна намын нэр хүндэд муугаар нөлөөлөх байсан. Цэдэнбал дарга бол зарим томчуул шиг өөрийнхөөрөө муйхарлан зүтгэдэггүй, бусдын саналыг сонсдог, асуудлын голыг олж чаддаг удирдагч гэдгийг тэр хурлаас улам ч сайн ойлгож мэдэрсэн билээ.

Энэ дашрамд түүний зан чанарын талаар товчхон хэлэхэд, тэрбээр хүмүүстэй тун эвлэгхэн харьцдаг, уурлаж зүс царайгаа хувьсгаж, хуруугаараа чичлэн загнадаггүй, зөөлөн намуу дуутай, нүднийхээ шилний цаанаас учиртайхан инээмсэглэж хардаг, хүсэлт тавьсан хүмүүст тусалдаг удирдагч байсан. Гэхдээ өөрийн нь эсрэг тэмцсэн хүмүүст “хатуухан нударганы” амт үзүүлж, үзэл бодлоо хамгаалж байсныг нь үгүйсгэхгүй. Үүнийг бодитойгоор эрэгцүүлэн бодвоос, улс төрийн үзэл баримтлал, эрх мэдэл, өндөр албан тушаалын төлөө тэмцэлдэх үед аль ч нийгэм, аль ч орны том, бага удирдагчид хийсээр ирсэн, одоо ч хийж байгаа, цаашид ч тохиолдох зүйл бололтой. Их эрх мэдэл хэнбугайг ч эвддэг нь хүн гэдэг амьтны үйлийн үр гэлтэй.

Би Прага хотноо “Энхтайван, социализмын асуудал” сэтгүүлийн редакцид МАХН-ын төлөөлөгчөөр, ЗХУ-д элчин сайдаар ажиллаж байхдаа манай улсын гадаад бодлогын асуудлаар түүнтэй ярилцаж, нэг

бус удаа үүрэг даалгавар авч явсны хувьд төрсөн сэтгэгдлээ хэлье. Хорин хэдэн наснаасаа Ю. Цэдэнбал Монгол Улсын тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлын төлөө 1939 ба 1945 оны дайнд оролцсон хийгээд анх 1945 онд Нью-Йоркт очиж БНМАУ-ыг НҮБ-д гишүүнээр элсүүлэх асуудал тавьж байсан, мөн ЗХУ, Хятадын гол удирдагчидтай уулзан ярилцаж явсан зэргээс эх орон, тусгаар тогтнол гэсэн эрхэмсэг дээд ухамсар, ариун нандин ойлголт нь бүрэлдэж төлөвшсөн гэж би хувьдаа боддог. Ю. Цэдэнбал Монгол улсын удирдагч байсан жилүүдэд дэлхий ертөнц цэрэг-улс төрийн хоёр бүлэглэлд хуваагдан үзэл суртлын "хүйтэн дайн" дэгдээсэн төдийгүй түүхэнд хамгийн их цус урсгасан "халуун дайн" шатаасан, манай хоёр аварга хөршүүд маань тэврэлдэн үнсэлцэж байснаа бие биенээ үзэж чадахаа болиод үе үе буун дуу гаргадаг болсон, ЗХУ-ыг эрхэмлэн шүтсээр яваад эцэстээ өөрөө Кремлийн хяналтанд орсон зэрэг нэн ээдрээтэй, эгзэгтэй нөхцөл байдалд тэрбээр тусгаар тогтнолоо тууштай хамгаалсаар улсаа НҮБ-д гишүүнээр элсүүлснээс гадна, "БНМАУ-ЗСБНХУ-БНХАУ" гэсэн гурвалсан холбооны сүлжээнд хүч мөхөс гүрнийхээ язгуур эрх ашиг, стратегийн сонирхлыг туйлбартай хамгаалсан идэвхтэй гадаад бодлого явуулж хэрэгжүүлсэн тул түүнийг дэлхийд нэртэй том дипломатч мөн гэж зүй ёсоор үнэлэх нь түүхэн үнэнд нийцнэ. Ю. Цэдэнбалын түүхэн гавъяаг ганц өгүүлбэрт багтааж товчхон хэлбэл, тэрбээр дэлхийн хөгжлөөс олон зуун жилээр хоцорсон Монгол улсад шинэ соёл иргэншлийн гэрэл туяа тусган ард түмнээ гэгээрүүлж, соёлжуулж, нийгмийн халдварт өвчнөөс салган эрүүлжүүлсний гадна феодализмын үед огт байгаагүй эдийн засгийн цоо шинэ цогцолбор буй болгосон төдийгүй, үе үеийн өвгөд дээдсийнхээ алтан амиараа олж авсан тусгаар тогтнолыг нүдний цөцгий мэт хайрлан баттай хамгаалж, улсынхаа нэр алдрыг даян дэлхийд цуурайтуулж чадсан Монголын ХХ зууны төрийн нэрт зүтгэлтэн, цогт эх оронч, холын хараатай улс төрч мөн бөлгөө.

Гэвч МАХН-ын эгнээнээс төрсөн зарим улс төрчид, мөн энэ намын ач ивээлээр боловсрол олж хүний зэрэгт хүрсэн хэсэг залуучууд хийгээд хэн дуртай нь 1990 оноос эхлэн сэтгэлийн их хөөрлөөр хэт туйлширч үзэл сурталжсан байр сууринаас түүнийг иш үндэсгүйгээр хараан зүхэж, "Буруу замаар будаа тээлгэсэн", "Монгол Улсаа ЗХУ-ын 16 дахь республик болгох гэсэн", "Эх орноосоо урваж КГБ-гийн тагнуул болсон" гэх зэргээр хайр найргүй гүтгэн доромжилдог болж билээ. Албаа хашиж явахад нь ам өрсөлдөн магтдаг байсан журмын нөхөд нь ч "өөрийн нь зөвшөөрснөөр" түүнийг эхлээд 1984 онд бүх албан тушаалаас нь чөлөөлж, дараа нь бүхэл бүтэн намаараа хийсэн алдаа дутагдлыг ганцааранд нь тохож 1990 оны 3 дугаар сарын 12-нд МАХН-аас хөөгөөд, удалгүй БНМАУ-ын хөдөлмөрийн баатар, улсын баатар, маршал цолыг нь хууль бусаар хурааж авсан юм. Энэ бүгд нь чухамдаа ардчиллын ариун далбааг ашиглаж Ю. Цэдэнбалыг ор үндэсгүй хилсдүүлсэн нэг ёсны шинэ маягийн цусгүй хэлмэгдүүлэл байлаа. Ийм үед миний бие "Ю. Цэдэнбал: Түүхэн үнэний тухай бодрол" хэмээх ном бичиж түүний ариун нэр төрийг сэргээх, Монголын түүхэнд зүй ёсоор эзлэх байр суурийг шударгаар, хартай

цагаантай нь үнэн зөвөөр тогтоох талаар үзэл бодлоо тодорхой илэрхийлж, Цэдэнбал судлалыг үүсгэн хөгжүүлэх нь чухал болжээ гэсэн санал дэвшүүлсэн юм. Миний номын сүнс болсон гол үзэл санаа нь Ю. Цэдэнбал бол Монголын XX зууны шинэхэн түүхийг мятрашгүй зүтгэлээрээ гардан бүтээлцэж хэзээ ч мартагдахгүй алдар нэрээ, хэн ч арилгаж чадахгүй тод мөрөө үлдээсэн түүхт хүн мөн, түүний нүгэл, буяныг гагцхүү түүх л дэнслэх ёстой, манай нийгэм, төр, оюун санааны хөгжил, хувьслын нэгэн зурвас үеийн түүхийг түүний намтар, үйл ажиллагаанаас тольдон харж болно гэсэн дүгнэлт хийсэнд оршино.

Энэ хүний удирдлаган дор олон жил ажиллаж зүтгэж явснаа амьдралын нь сүүлчийн гунигт жилүүдэд Москвад 6 жил түүнтэй хамт байх бас нэгэн хувь тавилан надад ноогдсон билээ. Цэдэнбал гуайн Москвад байх үеийн болон ерөөс түүний үйл ажиллагаа, үзэл баримтлал, гавьяа зүтгэлтэй холбогдсон олон асуудлыг номондоо бичсэн тул энэ удаад зөвхөн дараахи хоёр зүйлийг онцгойлж дурдъя.

Ю. Цэдэнбал дарга улс төрийн учир шалтгааны учир, өөрөөр хэлбэл нэг талаас Кремлийн удирдагчид түүнийг Монголд явуулахаас болгоомжилж өөрсдийнхөө хараа хяналтад байлгах нь зүйтэй гэж үзсэн, нөгөө талаас түүнийг залгамжилж өндөр сэнтийд нь заларсан хүн ч гэсэн Улаанбаатарт ирүүлж өөртөө ойрхон байлгах аас бас л эмээн болгоомжилж байснаас аргагүйн эрхэнд Москвад амьдрах болсон гэж боддог. Үүнээс гадна, цөмөөрөө зөвлөлтийн иргэн гэргий болон хөвгүүдийнхээ дэргэд Москвад байх болсон нь ойлгомжтой. Ингээд эх орноосоо алсад амьдарч эх нутгаа, төрөл төрөгсөд, анд нөхдөө санан мөрөөдөж, ганцаардахын зовлон амсаж, сэтгэлээр ихээхэн шаналж ностальгия өвчин туссан гэж хэлбэл нэг их хилсдүүлэхгүй бизээ. 1986 оны намар 70 насны ойгоор нь би Маршалын гэрт очиж баяр хүргээд, бэлэг дурсгалын зүйл гардуулаад гарахад минь Анастасия Ивановна, "Москвлагийн төвд, маш сайхан тохилог шоронд Цэдэнбал хоригдон сууж байна" гэж хэлснээс нь ургуулан би дотроо олон зүйлийг эрэгцүүлж бодсон. Гэр орныхоосоо нуугаад Монголдоо сэмхэн буцах юмсан гэж Цэдэнбал гуай надад нэг бус удаа ярьж байсан тул би түүний сэтгэлийн их гуниг зовлонг зүрхнийхээ угаас мэдэрсэн учир, тэр үед София хотод байсан дүү Ю. Аюушид нь дуулгасан бөгөөд тэр маань удалгүй хүрч ирсэн. Ингээд Аюуш бид хоёр ахыг нь Москвагаас сэм "оргуулж" Монгол руу явуулах оролдлого хийгээд бүтэлгүйтэж байсан удаатай. Гэсэн хэдий боловч Зөвлөлт, Монголын дээд удирдлагууд ярьж тохиролцсоны үр дүнд Ю. Цэдэнбал гуай гэргий Анастасия Ивановна Цэдэнбал-Филатовагынхаа хамт 1988 онд түр хугацаагаар Улаанбаатарт ирээд буцсан юм. Тэгэхэд нь би ажлаар нутагтаа ирэх байсан тул нэг онгоцоор хамт ниссэн бөгөөд бидэнд тохиолдсон нэгэн зүйлийг мартдаггүй юм. Бүх зорчигчдыг онгоцонд суулгасны дараа онгоц маань нисдэггүй, бараг цаг хэртэй онгоцон дотор биднийг хүлээлгэж байснаа "техникийн шалтгаанаар" онгоц нисэхийг түр хойшлууллаа гэж мэдэгдээд хүлээх танхимд оруулсан. Уг онгоцоо шалгаж үзээд нисэхэд саадгүй болохыг тогтоосны дараа хүмүүсээ суулгадаг хатуу журамтай шүү дээ. Цэдэнбал гуай бид хоёр

нилээд олон асуудлаар хуучилж суутал өглөөний 5 цагийн үед сая онгоц маань нисэж билээ. Сүүлд нь энэ тохиолдлын талаар эрэгцүүлэн бодоход, Цэдэнбал гуайг нутаг руу нь явуулах уу, эсхүл болих уу гэсэн асуудлаар Зөвлөлтийн томчуул санал зөрөлдсөн, тэгээд хамгийн дээд удирдлагаасаа эцсийн шийдвэр авах гэж хүлээсэн, ерөөс энэ онгоцыг яах вэ гэдгийг шийдэх зэрэг ямар нэг учир битүүлэг шалтгаан байсан юм биш биз дээ гэсэн бодол надад төрсөн тал бий. Ямар ч гэсэн онгоц маань саадгүй ниссээр "Буянт-Ухаа"-гийн буудалд газардахад Д. Моломжамц дарга гэргийтэйгээ бусад дарга нарын хамт цэцгийн баглаа барин Цэдэнбал гуайг халуун дотноор угтан авч байсан.

Өөр нэгэн зүйлийг зориуд тэмдэглэж хэлэхэд, Цэдэнбал гуайг зүйл бүрээр гүтгэж, хараан доромжлох зэргээр зүрх рүү нь "хорт сум" харваж байхад болон Төвийн даалгавраар түүнд очиж Элчин сайд миний сонордуулсан олон муу мэдээллийг сонссоныхоо дараа ч сэтгэлийн их тэнхээ, тэвчээр гарган өөрийгөө хамгаалсан үг нэг ч удаа хэлээгүйсэн. Энэ нь "түүх үнэн, худлыг ялгаж эрт, орой нэгэн цагт намайг гарцаагүй зөвтгөх болно" хэмээн оюун билэг, зөн совингоороо мэдэрч, итгэж байсных бизээ.

Элчин сайдын албыг хашиж дуусаад, нутагтаа бүр мөсөн буцахынхаа өмнөхөн 1990 оны 8 дугаар сарын эхээр би Ю. Цэдэнбал гуайтай уулзаж учир байдлаа хэлээд, эрүүл энх байж, амгалан тайван амьдрахыг ерөөсөн минь бид хоёрын хооронд болсон сүүлчийн яриа байжээ. Түүнээс хойш хагас жил гаруйхны дараа ертөнцийн мөнх бусыг үзүүлсэн бөгөөд үргэлж хүсэн мөрөөдөж, өдрийн бодол, шөнийн зүүд болж байсан хөв хөх тэнгэртэй, нарлаг сайхан Монгол орондоо шарил нь л ирж билээ. Би хувьдаа энэ их хүнийг тийм амархан өөд болж, хөх тэнгэрт халин одно гэж даанч бодоогүйсэн.

Цэдэнбал гуайг бүх албан тушаалаас нь өөрчилснийхөө дараа түүнийг ул үндэсгүй хохироон сэтгэл санаа, зүрхийг нь хөндсөн олон шийдвэрийг увуу цувуу, шат дараалан гаргасан бөгөөд тэр бүгдийг нь өрлүүгээ өшиглүүлж буй өвчтэй, өвгөн даргад Элчин сайдын хувьд би арга буюу мэдэгдэн, ихэс дээдсийн "халуун тогооны бариул" нь болж явсан, бас тэгээд сэтгэлийг нь баярлуулсан олигтой мэдээ сонсгож яваагүйдээ хувь хүний хувьд ихэд харамсаж явдгаа энэ дашрамд илэрхийлье.

Хурц ухаантай, холын хараатай төрийн том зүтгэлтэн, улс төрчийн хувьд Ю.Цэдэнбал гуай Монгол улсынхаа хувь заяаны талаар гэрээслэл бичиж үлдээснийг нь би түмэн олныхоо сонорт бас дахин хүргэе. Учир юу гэвэл, тэрбээр 1984 оны 8 дугаар 23-нд МАХН-ын Төв хорооны ээлжит бус VIII Бүгд Хурал болохоос гурван хоногийн өмнө ЗХУ-ын Коммунист намын Төв хороонд хандаж захидал бичсэн байх бөгөөд түүн дотроо өөрийнхөө улс төрийн үзэл баримтлал, гадаад ба дотоод бодлого, Монгол-Зөвлөлтийн харилцааны нарийн ширийн асуудлууд, хэтийн төлвийн талаар бодол санаагаа илэрхийлсэн нь лавтай. Тэр баримт бичгийг ОХУ-ын нууц архиваас авч үзвэл Цэдэнбал судлалыг ямар нэг туйлшралгүйгээр бодит үнэнд тулгуурлан хөгжүүлэхэд чухал ач

холбогдолтой болох тул энэ талаар Ц. Зоригийн тэргүүлсэн Цэдэнбалын Академи их зүйл хийх байх гэж найдаж байна.

Харин "Цэдэнбалын өвийг хамгаалах, судлах сан"-гийн зарим эрдэмтэд шиг ор үндэсгүй юм санаанаасаа зохиогоод байвал бусдын дэмжлэг авах байтугай дургүйцэл зэвүүцэл төрүүлж болзошгүй гэдгийг дараахи баримтад тулгуурлан энэ дашрамд хэлье. Дээрх сангийн гол судлаач нь гэгддэг доктор А. Нямаа "Үнэн үү?" (1996-9-13) гэсэн хачин нэртэй сонинд "П. Очирбат Ю. Цэдэнбалыг хэлмэгдүүлсэн гэж үү?" гэсэн "судалгаа" нийтлүүлэхдээ 1990 оны 3 дугаар сард болсон НТХ-ны Бүгд хурал дээр Ю. Цэдэнбалын алдар цолыг хурааж авах саналыг 5 хүн гаргасан гэж тэмдэглээд тэдний тоонд миний нэрийг оруулсан байлаа. Энэ "судалгаа" үнэн үү гэвэл огт худлаа, цэвэр гүтгэлэг! Бас тэгээд хөөх талаар нэн идэвхтэй зүтгэж, санал гаргаж байсан хүмүүсийг дурьдалгүй өнгөрчээ. Хан Хэнтий нутгийн өчүүхэн миний хувьд гэвэл, харин ч Ю. Цэдэнбалыг намаас шууд хөөхийг эсэргүүцэж, Москва дахь ЭСЯ-ны дэргэдэх намын үүрийн хурлаар хэлэлцэн хөөх тухай Бүгд хурлын тогтоолын төсөл тараасныг нь намын дүрэмд таарахгүй зүйл гэж үзээд түүний үйл ажиллагаанд улс төрийн үнэлэлт, дүгнэлт Бүгд хурлаас өгч байж уул асуудлыг шийдэх санал гаргасан юм. Миний саналыг дуртай дургүй хүлээж авсны эцэст, МАХН-аас Ю. Цэдэнбал даргыг хөөх тухай Бүгд хурлын тогтоолыг хэлэлцэн санал хураахад би түдгэлзсэн юм. Надтай адил түдгэлзсэн хоёр дахь хүн одоо амьд сэрүүн явж байгаа. Энэ бүгдийг би Цэдэнбал гуайн тухай номондоо тодорхой бичсэн боловч доктор маань ойшоож үзээгүй бололтой. Тэгвэл түүний "судалгаагаа" нийтлүүлсэн "Үнэн үү?" сонинд биш, жинхэнэ "Үнэн" (1990-3-15) сонинд, Бүгд хурал дээр миний хэлсэн үгийг бүрэн эхээр нь нийтэлсэн бөгөөд түүнийг уншаад үзвэл намаас нь хөөе, алдар цолыг нь хурааж авъя гэсэн үг, үсэг ч олж үзэхгүй. Энэ бол хөдөлшгүй үнэн баримт юм. Дээрхийн адил гүтгэлэг зохиох, эсхүл нутгархаж Ю.Цэдэнбалыг зөвхөн магтаж мандуулах, нөгөө талаас түүний тухай ном бичихлээр ойлгоогүй байж "сайн аавын нэрийг гурав худалдах гэлээ", "МАХН-ыг хараахаа мартсангүй" хэмээн ортодокс "коммунист" А. Болат шиг хараан зүхэх аргаар Цэдэнбал судлалыг хөгжүүлэхийг эрмэлзвэл тэр нь судлал биш "Цэдэнбал өмгөөлөл" болж хувирна гэдгийг шуудхан хэлчихье.

Ю. Цэдэнбал гуайн 85 насны ойг тохиолдуулан бичсэн энэхүү дурсамжаа, *"Амьдрал ахархан, гэвч алдар хүнд мөнх байж болно"* хэмээн суут Т. Цицероны айлдсан үгээр төгсгөө.

Former head of the MPRP Central Committee, resident representative of the MPRP to journal "Socialism and Peace" during his service as Ambassador of Mongolia to the Soviet Union wrote about U.Tsedenbal's life & last days in power, as party and state leader.